



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Бэлгэ тэмдгийн загвар
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны бэлгэ тэмдгийн загвар, тайлбарыг хавсралтаар баталсугай.

2. Бэлгэ тэмдгийг холбогдох журмын дагуу хэрэглэхийг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга /цагдаагийн хурандаа О.Зоригт/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Бат-Өлзий/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН
Захиргааны удирдлагын газрын дарга,
цагдаагийн хурандаа

О.БААТАРЖАВ

Б.Бат-Өлзий



Цагдаагийн ерөнхий газрын
даргын 2019 оны 08 дүгээр
сарын 08-ны өдрийн 10 дугаар
тушаалын хавсралт

УХГ/004

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ БЭЛГЭ ТЭМДЭГ, ТҮҮНИЙ ТАЙЛБАР



Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны бэлгэ тэмдэг нь тус албаны чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг илтгэх бөгөөд дараах агуулгаар ойлгоно.

1. Монголчуудын сүр, сүлд, хүч болсон цэргийн уламжлалыг хадгалсан түүхэн утга агуулгыг "Их бамбай"-аар илэрхийлдэг тул ард, иргэдийн амар тайван байдлыг найдвартай сахин хамгаалах утгыг бэлгэдэн бэлгэ тэмдгийн ерөнхий дүрсийг "бамбай" хэлбэрээр илэрхийлсэн.


2. Бэлгэ тэмдэг нь бүхэлдээ "цэнхэр" өнгийн дэвсгэртэй байх бөгөөд энэ өнгө нь итгэлцэл, үнэнч байдлын илэрхийлэл болдог, үргэлж өндөр дээд хөх тэнгэр мэт байхыг бэлгэджээ.

3. Бамбайны төв дээд хэсэгт Монгол Улсын цагдаагийн албаны бэлгэдэл, хурд хүч, эр зориг, авхаалж самбаа, эрч хүчийн илэрхийлэл "шонхор шувуу"-г байрлуулж, өндөр тэнгэрт дэвэн нисэж буйгаар үзүүлсэн нь хэний ч нөлөөнд үл автах, зөвхөн өргөсөн тангарагтаа үнэнч байх утгыг илтгэнэ.

4. Бамбайны төв хэсэгт албаны чиг үүргийг дэлгээтэй номын хуудсаар улаан, цэнхэр, улаан өнгөөр сум хэлбэртэй дүрсэлсэн нь шуурхай байдлыг илэрхийлж, ном нь мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээний ажлыг шинжлэх ухааны онол, арга зүйд үндэслэн явуулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах утгыг илэрхийлнэ.

5. Компьютерын дэлгэц ба түүний гол төв хэсэгт харилцаа холбооны антенн, радио долгионы болон интернетийн сүлжээний цацрагийг илтгэх дүрс байрлуулж, хязгааргүй орон зайд асар хурдтайгаар тархаж буй мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшлийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг илэрхийлсэн.

6. Бамбайн хүрээ болон "Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба" гэсэн үгийг алтлаг шар өнгөөр бичсэн нь нарны гэрэл, оюун ухаан, авъяас чадвар, бүтээлч сэтгэлгээг илэрхийлсэн утгатай болно.





**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ
УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

**Албаны бэлгэ тэмдгийг
хэрэглэх журам батлах тухай**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136 дугаар зүйлийн 136.4.2 дахь хэсгийн "г", 136.5.2 дахь хэсгийн "г" дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны "Бэлгэ тэмдгийн загвар батлах тухай" А/10 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны бэлгэ тэмдгийг хэрэглэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс /цагдаагийн хурандаа Д.Пандиймаа/, Статистик мэдээллийн хэлтэс /цагдаагийн хурандаа П.Батбаатар/, Дүн шинжилгээ, судалгааны хэлтэс /цагдаагийн хурандаа О.Зоригоо/, Мэдээллийн технологи, холбооны төв /цагдаагийн хурандаа Ц.Отгонбат/, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /цагдаагийн хурандаа Н.Амарзаяа/, Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс /цагдаагийн дэд хурандаа Х.Чинтөгс/, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын хэлтэс, тасгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

О.ЗОРИГТ

ХУУЛБАР ҮНЭН:

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, цагдаагийн
хурандаа

Д.Пандиймаа



МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ БЭЛГЭ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Зорилго: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны “Бэлгэ тэмдгийн загвар батлах тухай” А/10 дугаар тушаалаар баталсан Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны бэлгэ тэмдгийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

I. Албаны бэлгэ тэмдгийг хэрэглэх:

1.1. Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны хаяг, урилга, алба хаагчийн нэрийн хуудас, “Баярын бичиг”, “Хүндэт дэвтэр”;

1.2. Алба, харьяа нэгжүүдээс танилцуулах “Илтгэх хуудас”, “Танилцуулга”, “Мэдээлэл” зэрэг хэвлэмэл хуудас;

1.3. Алба, харьяа нэгжийн туг, мэдээллийн болон хүндэтгэлийн самбар, албан өрөө;

1.4. Алба, харьяа нэгжийн нэрийн өмнөөс тэмцээн, уралдаанд оролцох баг, тамирчдын биеийн тамирын хувцас, хэрэглэл, өмсгөл;

1.5. Албанаас эрхлэн гаргасан ном, товхимол, бэлэг дурсгалын зүйлс, ажлын хавтас, тэмдэглэлийн дэвтэр, үзэг;

1.6. Алба, харьяа нэгжийн үйл ажиллагааг сурталчилж байгаа цахим хуудас, дүрст танилцуулга, зурагт хуудас;

II. Хориглох:

2.1. Албаны бэлгэ тэмдгийн хэмжээ нь янз бүр байж болох боловч түүний хэмжээний харьцаа, хэлбэр, загвар, өнгийг өөрчлөх;

2.2. Албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, нэрийн үсэг гэх мэт холбогдох хууль тогтоомжоор хориглосон тохиолдолд хэрэглэх;

2.3. Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцас, хэрэглэл, тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд байршуулах;

2.4. Албаны бэлгэ тэмдгийг иргэн, хуулийн этгээд дуурайлган хийх, хувилах, хуулбарлах, олшруулах, ашиг олох зорилгоор ашиглах;

